

ШАРГА СУМД 2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД БОЛСОН
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2019.01.25

Баянгол

МЭДЭЭЛЛИЙН ЦАГИЙГ ХИЙЛЭЭ

Засгийн газрын тогтоолын дагаа 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг мэдээллийн цагийг энэ сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Мэдээллийн цагаар сумын удирдлагууд цаг үеийн ажил танилцуулж үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн Төрийн сангийн мэргэжилтэн, Улсын бүртгэгч нар статистик мэдээг танилцуулсан. Мэдээллийн албан байгууллагуудын дарга эрхлэгч нар, ЗДТГ-ын мэргэжилтнүүд, цагдаа, хэсгийн төлөөлөгч, эрчим хүчний салбарын эрхлэгч нар хамрагддаг.

БАЯНГОЛ БАГААС АНХНЫ УЛСЫН АВАРГА

МАЛЧИН ТОДОРЛОО

Сар шинийн босгон дээр тус сумын Баянгол багийн малчин, тэмээчин С.Алтансүх улсын аварга малчнаар шалгарсан байна. Энэ нь Шарга сумын Баянгол багаас төрж буй анхны улсын аварга малчин боллоо.

АЙМАГ, СУМЫН АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

Энэ онд **аймгийн аварга малчнаар** Баянгол багийн малчин Б.Баасандорж, Сондуулт багийн малчин П.Түвшинжаргал, Д.Баттулга, М.Батцэнгэл, Хамтын хүч багийн малчин Б.Баатар, П.Энхбаатар, Улаантуг багийн малчин Д.Ганболд, Э.Ганзориг, **аймгийн аварга хадланчаар** Д.Дунхар-Ийчил, **аймгийн аварга саальчнаар** С.Оюунцэцэг нар тодорлоо.

Сумын аварга малчнаар: Баянгол багийн малчин О.Амартүвшин, Б.Ганхуяг, Хамтын хүч багийн малчин Н.Бат-Оргил, М.Эрдэнэбаатар, Н.Батсүх, Сондуулт багийн малчин С.Гантөмөр, Г.Мөнхбат, Улаантуг багийн малчин Д.Наранбаатар, Н.Батбуян, О.Гансүх, Т.Даваадорж, Х.Төмөр-Очир, З.Мөнгөншагай нар тодорлоо. Мөн Хамтын хүч багаас С.Сандаг-Очир, Д.Банди, Улаантуг багаас Н.Батжаргал, Д.Наранбаатар, Сондуулт багаас Д.Баттулга, Л.Түвшин, Т.Дагвасүрэн нарын малчид **шинэ мянгат малчин** болсон байна.

Сумын алдарт уяачаар: Баянгол багаас Д.Дамдиндорж, Г.Уламбаяр, Б.Нэргүй, Ц.Бөхсумъяабазар, Хамтын хүч багаас Я.Гэрэлчулуун, Баз. Батсайхан, Х.Амаржаргал, Т.Ганбаатар, Сондуулт багаас Л.Эрдэнэбаатар, Улаантуг багаас А.Батдэлгэр, Б.Адъяабат, Б.Ганхуяг, Х.Тогоонтөмөр нар сумын алдарт уяач боллоо.

Сумын тэргүүний хадланчаар: Хамтын хүч багийн хадланч Х.Амаржаргал, **Сумын тэргүүний тариаланчаар:** Баянгол багийн тариаланч Н.Батбаяр нар тодорлоо.